



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 171

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө хүлээн авах,
бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Хэнтий аймгийн Засаг даргын 2019 оны А/254, Увс аймгийн Засаг даргын 2021 оны А/494 дүгээр захирамж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хэнтий, Увс аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр бий болсон, нийт 48,402,470.00 (дөчин найман сая дөрвөн зуун хоёр мянга дөрвөн зуун далан) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу төрийн өмчид хүлээн авч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа Хэнтий, Увс аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ё.Мөнхзул, Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Л.Батсайхан болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасгай:

2.1.Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001533

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 06 дугаар сарын 06 ны өдрийн
06 дугаар тогтоолын хавсралт

УВС, ХЭНТИЙ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙГ ТӨРИЙН ӨМЧИД
ХҮЛЭЭН АВЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1.Хэнтий аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс					
1	Газар /газрын эрх/, Хэрлэн сум, 3 дугаар баг, Баянмөнхийн Баатрууд гудамж	м2	1200	1,038,000.00	1,038,000.00
2	Принтер /HP LaserJet/	ш	2	319,000.00	638,000.00
3	Принтер /HP LaserJetPro/	ш	5	528,000.00	2,640,000.00
4	Скайнер /Epson DS/	ш	1	1,518,000.00	1,518,000.00
5	Компьютерын дэлгэц /Dell 2216H/	ш	3	346,500.00	1,039,500.00
6	Процессор	ш	3	1,364,990.00	4,094,970.00
	Дүн				10,968,470.00
2.Увс аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс					
7	Архивын нягтруулсан шүүгээ /Төмөр, саарал/	ш	34	1,080,000.00	36,720,000.00
8	Галын хор /Powder, А,В,С,Е/	ш	3	238,000.00	714,000.00
	Дүн				37,434,000.00
	Нийт дүн				48,402,470.00 (дөчин найман сая дөрвөн зуун хоёр мянга дөрвөг зуун далан)